



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP

# МОНГОЛ ХЭЛ II

# ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар хот  
2023 он



Б.АЯУЖАН, Ж.ГЭРЭЛМАА, А.АХХАЙЫН, А.БАУЫРЖАН

# МОНГОЛ ХЭЛ II

## ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын  
сургуулийн 2 дугаар ангид судална.

Улаанбаатар хот  
2023 он

ННА 74.1  
ДАА 372  
М-692

Монгол хэл II: Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын сургуулийн  
2 дугаар ангийн гарын авлага. /УБ.2023-96 нүүр/

Энэхүү гарын авлагыг Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Дэлхийн Банкны  
хамтран хэрэгжүүлж буй "Боловсролын чанарын шинэчлэл" төслийн  
дэмжлэгээр боловсруулж, хэвлэв.

© Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

ISBN: 978-9919-9714-9-6



## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	4
I БҮЛЭГ. МОНГОЛ ХЭЛНИЙ ЦАГААН ТОЛГОЙ .....	5
II БҮЛЭГ. БИ .....	17
III БҮЛЭГ. ГЭР БҮЛ.....	25
IV БҮЛЭГ. СУРГУУЛЬ, АНГИ .....	31
V БҮЛЭГ. АЖИЛ ХӨДӨЛМӨР.....	41
VI БҮЛЭГ. БИДНИЙ ОРЧИН .....	49
VII БҮЛЭГ. ХООЛ ХҮНС .....	57
VIII БҮЛЭГ. АМЬТАД .....	65
IX БҮЛЭГ. БАЙГАЛЬ ДЭЛХИЙ.....	73
X БҮЛЭГ. ХУВЦАС .....	81
XI БҮЛЭГ. ЁС ЗАНШИЛ, БАЯР ЁСЛОЛ.....	87
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАТАТГАЛ.....	95

## ТАНИХ ТЭМДЭГ



**СОНСОХ**



**ЯРИХ**



**УНШИХ**



**БИЧИХ**



**ҮГСИЙН САН**



## ӨМНӨХ ҮГ

Монгол хэлийг эхлэн суралцаж байгаа хос хэлний сургалттай ерөнхий боловсролын сургуулийн хоёрдугаар ангийн сурагчдад зориулан "Гарын авлага" болон "Дасгал ажлын дэвтэр" гэсэн хоёр номыг та бүхний гарт хүргэж байгаад баяртай байна.

Монгол хэлний "Гарын авлага"-д сурагчдын монгол хэлний үгийн санг нэмэгдүүлэх, сонсох, ярих, унших, бичих чадварыг хөгжүүлэх зорилготой зурагт толь, харилцан яриа, эх, дуу, шүлэг, оньсого, таавар, зүйр цэцэн үг орсон.

Монгол хэлний "Дасгал ажлын дэвтэр"-т сурагчдын монгол хэлний чадварыг хөгжүүлэх, үнэлэхэд зориулсан олон төрлийн дасгал, даалгаврыг сонирхолтой хэлбэрээр оруулж өгснөөрөө онцлогтой.

Номыг ашиглахад багш нар, эцэг эх, асран хамгаалагчаасаа дэмжлэг аваарай.

Номоо гамтай хэрэглэж, хичээн суралцахыг хүүхэд багачууд, дүү нартаа зөвлөж байна.

Та бүхэндээ амжилт хүсье.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай!

Зохиогчид

# I БҮЛЭГ. МОНГОЛ ХЭЛНИЙ ЦАГААН ТОЛГОЙ

## ЗУРАГТ ТОЛЬ

<b>А</b> <i>Аа</i> АЛИМ 	<b>Б</b> <i>Бб</i> БОТГО 	<b>В</b> <i>Вв</i> ВААР 	<b>Г</b> <i>Гг</i> ГЕЛӨГ 	<b>Д</b> <i>Дд</i> ДЭГДЭЭХЭЙ 
<b>Е</b> <i>Ее</i> ЕЭВЭН 	<b>Ё</b> <i>Ёё</i> ЁОТОН 	<b>Ж</b> <i>Жж</i> ЖИМС 	<b>З</b> <i>Зз</i> ЗАРАА 	<b>И</b> <i>Ии</i> ИШИГ 
<b>Й</b> <i>Йй</i> ТУУЛАЙ 	<b>К</b> <i>Кк</i> КОМПЬЮТЕР 	<b>Л</b> <i>Лл</i> ЛУУВАН 	<b>М</b> <i>Мм</i> МУУР 	<b>Н</b> <i>Нн</i> НОМ 
<b>О</b> <i>Оо</i> ОНГОЦ 	<b>Ө</b> <i>Өө</i> ӨНДӨГ 	<b>П</b> <i>Пп</i> ПУУЖИН 	<b>Р</b> <i>Рр</i> РОБОТ 	<b>С</b> <i>Сс</i> САР 
<b>Т</b> <i>Тт</i> ТУГАЛ 	<b>У</b> <i>Уу</i> УНАГА 	<b>Ү</b> <i>Үү</i> ҮНЭГ 	<b>Ф</b> <i>Фф</i> ФОТО АППАРАТ 	<b>Х</b> <i>Хх</i> ХУРГА 
<b>Ц</b> <i>Цц</i> ЦЭЦЭГ 	<b>Ч</b> <i>Чч</i> ЧОНО 	<b>Ш</b> <i>Шш</i> ШОО 	<b>Щ</b> <i>Щщ</i>	<b>Ъ</b> <i>ъ</i>
<b>Ы</b> <i>ы</i>	<b>Ь</b> <i>ь</i> МОРЬ 	<b>Э</b> <i>Ээ</i> ЭРВЭЭХЭЙ 	<b>Ю</b> <i>Юю</i> ЮҮЛҮҮР 	<b>Я</b> <i>Яя</i> ЯМАА 



# ДАСГАЛ 1

а. Уншаарай.

Аа	Ээ	Ии	Оо	Уу	Өө	Үү
алим	эрвээхэй	ишиг	онгоц	унага	өндөг	үнэг

б. Уншаарай.

алим      ишиг      онгоц      өндөг      үнэг      унага      эрвээхэй

в. Эгшиг үсгийг зөв дуудаарай.

а э и о у ө ү      а э и о у ө ү      а э и о у ө ү      а э и о у ө ү      а э и о у ө ү      а э и о у ө ү      а э и о у ө ү

г. Үсгийг нэрлэж сурцгаая.



**А** – дармал, том “а” үсэг

*А* – бичмэл, том “а” үсэг

**а** – дармал, жижиг “а” үсэг

*а* – бичмэл, жижиг “а” үсэг

д. Цэвэр сайхан бичээрэй.

*Аа Ээ Ии Оо Уу Өө Үү*



а. Богино, урт, хос эгшгийг уншаарай.

а – аа – ай

э – ээ – эй

о – оо – ой

у – уу – уй

ү – үү – үй

ө – өө

и – ий – ы

б. Шүлгийг тод, чанга уншаарай. Цээжлээрэй.



### Эгшиг үсэг

Үсэг үсэг олуулаа  
Үндсэн эгшиг долуулаа  
Эгшиг үсэг олуулаа  
Эгшиг үсэг долуулаа  
А, Э, И, О, У, Ө, Ү

(Ж.Дашдондог)

а	+ы
о	
у	
э	+ий
и	
ө	
ү	



в. Богино, урт, хос эгшгийг ялгаж уншаарай.




**Богино эгшиг:** а, э, и, о, у, ө, ү

**Урт эгшиг:** аа, ээ, ий, оо, уу, өө, үү, ы

**Хос эгшиг:** ай, эй, ой, уй, үй









г. Цэвэр сайхан бичээрэй.





## ДАСГАЛ 3

а. Уншаарай.

<b>Мм</b>	<b>Сс</b>	<b>Рр</b>	<b>Хх</b>
			
м у у р	с а р	р о б о т	х у р г а
<b>Вв</b>	<b>Лл</b>	<b>Нн</b>	<b>Шш</b>
			
в а а р	л у у в а н	н о м	ш о о

б. Уншаарай.

	а	э	и	о	у	ө	ү
М	ма маа	мэ мээ	ми мий	мо моо	му муу	мө мөө	мү мүү
С	са саа	сэ сээ	си сий	со соо	су суу	сө сөө	сү сүү
Р	ра раа	рэ рээ	ри рий	ро роо	ру руу	рө рөө	рү рүү
Х	ха хаа	хэ хээ	хи хий	хо хоо	ху хуу	хө хөө	хү хүү
В	ва ваа	вэ вээ	ви вий	во воо	ву вуу	вө вөө	вү вүү
Л	ла лаа	лэ лээ	ли лий	ло лоо	лу луу	лө лөө	лү лүү
Н	на наа	нэ нээ	ни ний	но ноо	ну нуу	нө нөө	нү нүү
Ш	ша шаа	шэ шээ	ши ший	шо шоо	шу шуу	шө шөө	шү шүү

г. Цэвэр сайхан бичээрэй.

Мм, Сс, Рр, Хх, Вв, Лл, Нн, Шш,  
мал, сар, хурга, луван, ном, шоо, муур



а. Уншаарай.

л, м, н, с, ш, х, в, р

сар	савар	сэрээ	өглөө	хавар
шар	шавар	ширээ	үглээ	намар

б. Эхийг уншаарай.

### Ном

Энэ бол миний ном. Номын нэр “Сайн хүү”.  
Хулан шинэ ном авлаа. Номин, Анар, Марал нар  
олон ном уншлаа.



в. Уншаад, ярианы дасгал хийгээрэй.

Энэ бол .

Энэ бол улаан .

Марал авлаа.

Энэ бол .

Энэ бол миний .

Хулан уншлаа.

Энэ бол .

Энэ бол шар .

Ах харлаа.

г. Богино, урт, хос, эгшигтэй үгсийг уншаарай.

ав	ул	үл	хав	сар
аав	уул	үүл	хаав	саар
айв	уйл	үйл	хайв	сайр

д. Цэвэр сайхан бичээрэй.

Энэ бол алми. Марал алми авлаа.

Энэ бол ном. Хулан ном уншлаа.

Энэ бол муур. Ах муур харлаа.



## ДАСГАЛ 5

а. Уншаарай.

Гг



г ө л ө г

Дд



д э г д э э х э й

Бб



б а а в г а й

Тт



т у у л а й

Цц



ц э ц э г

Чч



ч о н о

Зз



з а р а а

Жж



ж и м с

б. Уншаарай.

	а	э	и	о	у	ө	ү
М	га гаа	гэ гээ	ги гий	го гоо	гу гуу	гө гөө	гү гүү
С	да даа	дэ дээ	ди дий	до доо	ду дуу	дө дөө	дү дүү
Р	ба баа	бэ бээ	би бий	бо боо	бу буу	бө бөө	бү бүү
Х	та таа	тэ тээ	ти тий	то тоо	ту туу	тө төө	тү түү
В	ца цаа	цэ цээ	ци ций	цо цоо	цу цуу	цө цөө	цү цүү
Л	ча чаа	чэ чээ	чи чий	чо чоо	чу чуу	чө чөө	чү чүү
Н	за заа	зэ зээ	зи зий	зо зоо	зу зуу	зө зөө	зү зүү
Ш	жа жаа	жэ жээ	жи жий	жо жоо	жу жуу	жө жөө	жү жүү

в. Цэвэр сайхан бичээрэй.

Гг, Дд, Бб, Тт, Цц, Чч, Зз, Жж  
 гөлөг, дэгдээхэй, баавгай, туулай,  
 цэцэг, чоно, зараа, жимс



а. Уншаарай.

б – в    д – т    х – г    ж – з    ч – ц    с – ш



зай    зуу    дуу    далбаа    дээвэр    газар    дайрах  
цай    цуу    туу    талбай    тээвэр    хацар    тайрах

б. Богино, урт, хос, эгшигтэй үгсийг уншаарай.

тал	зал	дар	тор	тул
таал	заал	даар	тоор	туул
тайл	зайл	дайр	тойр	туйл

в. Зургийн дагуу ярилцаарай.



Хулан



Бат



Болд



Алимаа

- Энэ хэн бэ?

- Энэ бол Хулан.

- Энэ хэн бэ?

- Энэ бол Бат.

-Тэр хэн бэ?

-Тэр бол Болд.

-Тэр хэн бэ?

-Тэр бол Алимаа.

г. Цэвэр сайхан бичээрэй.

- Энэ хэн бэ?  
- Энэ бол Бат.  
- Тэр хэн бэ?  
- Тэр бол Алимаа.

- Чиний нэр хэн бэ?  
- Миний нэр Хулан.  
- Чиний нэр хэн бэ?  
- Миний нэр Болд.



Өгүүлбэрийг том үсгээр эхэлж, төгсгөлд нь цэг (.) тавина.  
Асуух өгүүлбэрийн төгсгөлд асуултын тэмдэг (?) тавина.



## ДАСГАЛ 7

а. Уншаарай.

Яа	Ёё	Ее	Юю
			
я м а а	ё о т о н	е э в э н	ю ү л ү ү р
 я=й+а	 ё=й+о	 е=й+э	 ю=й+у

б. Уншаарай.

яа	еэ	уя	бие	оё	хөөе
яу	еө	уяа	биеэ	оёо	хөөө
ёо	юу	хая	үе	гоё	Юндэн
ёу	юү	хаяа	үеэ	гоёо	юүдэн

в. Цэвэр сайхан бичээрэй.

Яа, Ёё, Ее, Юю, яа, ёо, еэ, юу, юүмүр  
Энэ юу вэ? Ёотон байна. Ямаа яргүй идэв.

г. Эгшиг үсгийг нүдлээрэй.



### Эгшиг үсэг 13

а, э, и, о, у, ө, ү, я, е, ё, ю, й, ы

#### Үндсэн эгшиг 7

а, э, и, о, у, ө, ү

#### Туслах эгшиг 6

я, е, ё, ю, й, ы



а. Уншаарай.



ЗӨӨЛНИЙ  
ТЭМДЭГ



50

Х О Н Ъ

М О Р Ъ

Т О Т Ъ

Т А Х Ъ

Т А В Ъ

б. Уншаарай.

ам – амь

бар – барь

ан – ань

сольж барьсан гэр

ах – ахь

тав – тавь

он – онь

сорьж тарьсан үр

в. Өгүүлбэрийг уншаарай.

Энэ бол хонь.

Энэ бол тоть.

Энэ бол тавийн тоо.

Энэ бол морь.

Энэ бол тахь.

Энэ бол тавын тоо.

г. Эхийг уншаарай.



Яст мэлхий

Яст мэлхий нь ясан хуягтай. Явах хөдлөх нь удаан ч урт настай амьтан.

Би яст мэлхий тэжээдэг. Манайд хоёр яст мэлхий бий. Яст мэлхий хөөрхөн амьтан.

д. Цэвэр сайхан бичээрэй.

ь ь ь, хонь, морь, тахь, тавь

Энэ юу вэ? Энэ бол тоть.

Хурдан морь унах сайхан.

Яст мэлхий урт настай амьтан.




ТЭМДЭГ ҮСЭГ



Ь - зөөлний тэмдэг



ь - хатуугийн тэмдэг



а. Уншаарай.

ав – авъя  
 яв – явъя  
 унш – уншъя  
 зур – зуръя  
 бод – бодъя  
 сонс – сонсьё

харь – харья  
 ярь – ярья  
 хэл – хэлье  
 бич – бичье  
 өг – өгье  
 үз – үзье

тарья – таръя  
 харья – харъя  
 урья – урья  
 сорья – сорья  
 больё – больё  
 төөлье – тоольё

б. Шүлгийг тод чанга уншаарай.

Маамуу нааш ир

Маамуу нааш ир, манайд хоёулаа тоглоё  
 Аав ээж хоёрын авчирсан тоглоом бий шүү  
 Морь унаж давхия, машин барьж явъя  
 Ном сонин уншъя, ногоон модоо тарья.



в. Цэвэр сайхан бичээрэй.

Ь ь ь ь ь ь ь ь ь ь

Ном уншъя. Шоо бодъя. Дуу дуулъя.  
 Зурал зуръя. Зургаа бидъя. Чмэр ярья.  
 Сайхан бичье. Хоёулаа тоглоё.



а. Уншаарай.

Тэр юу вэ?

Пп	Кк	Фф	Щщ
			
п а н д а	к а р т	ф л а ш	б о р щ

б. Уншаарай.

карт	парк	фото	щи
кино	пүүз	фтор	Щорс
касс	пуужин	Франц	щетка
цирк	панда	кофе	борщ

в. Өгүүлбэрийг уншаарай.



Хүүхэлдэйн кино үзлээ. Пуужин хөөрлөө. Ах компьютер тоглов.

г. Цэвэр сайхан бичээрэй.

*Пп, Кк, Фф, Щщ цирк фото ши пүүз  
Фото зураг авлаа. Пуужин хөөрлөө.*

д. Гийгүүлэгч үсгийг нүдлээрэй.




**Гийгүүлэгч үсэг 20**

б, в, г, д, ж, з, к, л, м, н, п, р, с, т, ф, х, ц, ч, ш, щ.



# ДАСГАЛ 11

а. Цагаан толгойн 35 үсгийг нэрлээрэй.



б. Шүлгийг тод чанга уншаарай.

### Гучин таван найз

Алтан номын үсэг бид	Үсэг бид эвтэй
Ах дүү гучин тавуулаа	Үйлс зорилго нэгтэй
Эрдэм номын үсэг бид	Үсэг бүхэн тустай
Эгч дүү гучин тавуулаа	Үг бүтээх хувьтай.



Монгол хэлний цагаан толгой 35 үсэгтэй.

в. Минутаар уншаарай.





мал	элс	алим	хонх	өндөг	5
сар	өрх	ишиг	жимс	зараа	10
бич	унш	үсэг	хулс	саван	15
гэр	пүүз	хонь	карт	онгоц	20
хэл	ямаа	кино	хоёр	лууван	25
шөл	гоё	морь	навч	цэцэг	30
ном	муур	чоно	цирк	мөнгө	35
хөх	сайн	үнэг	парк	зураг	40
цай	олс	фото	ганц	хурга	45
нэг	өвс	ухна	савх	баавгай	50

г. Цэвэр сайхан бичээрэй.

Аа Ёё Вв Гг Дд Ее Ёё Жж Зз  
 Ии Йй Кк Лл Мм Нн Оо Өө Тт  
 Рр Сс Тт Уу Үү Фф Хх Цц  
 Чч Шш Щщ Ъ ъ Ыы Яя

## II БҮЛЭГ. БИ

### ЗУРАГТ ТОЛЬ

 <p>толгой</p>	 <p>нүд</p>	 <p>чих</p>	 <p>ам</p>	 <p>хамар</p>	 <p>хэл</p>
 <p>шүд</p>	 <p>үс</p>	 <p>гар</p>	 <p>хуруу</p>	 <p>алга</p>	 <p>хөл</p>
 <p>өвдөг</p>	 <p>хүзүү</p>	 <p>мөр</p>	 <p>гэдэс</p>	 <p>бие эрхтэн</p>	 <p>урт богино</p>
 <p>том, жижиг</p>	 <p>эрэгтэй</p>	 <p>эмэгтэй</p>	 <p>хүүхэд</p>	 <p>хүү</p>	 <p>охин</p>
 <p>би</p>	 <p>та</p>	 <p>чи</p>	 <p>энэ</p>	 <p>тэр</p>	 <p>хэн?, юу?</p>
 <p>тоо</p>	 <p>тэг</p>	 <p>нэг</p>	 <p>хоёр</p>	 <p>гурав</p>	 <p>дөрөв</p>
 <p>тав</p>	 <p>зургаа</p>	 <p>долоо</p>	 <p>найм</p>	 <p>ес</p>	 <p>арав</p>
 <p>мэндлэх</p>	 <p>танилцах</p>	 <p>босох</p>	 <p>суух</p>	 <p>тоолох</p>	 <p>өвдөх</p>



# ДАСГАЛ 1

## а. Уншаарай.



багш сурагч  
Сайн байна уу?  
Өглөөний мэнд!

хүүхэд  
Сайн байцгаана уу?  
Өдрийн мэнд!

хүүхдүүд  
Баяртай!

## б. Харилцан яриаг уншаарай.

Сайн байцгаана уу?  
Хүүхдүүд ээ.

Сайн.  
Сайн байна уу?  
Багш аа.

Өглөөний мэнд!  
Багш аа.

Өглөөний мэнд!  
Хүүхдүүд ээ.

Өглөөний мэнд!  
Багш аа.

## в. Ярилцаарай.

Сайн байна уу?  
Хулан.

Сайн,  
сайн байна уу?  
Бат.

Өдрийн мэнд!

Өдрийн мэнд!

Баяртай!

Баяртай!

## г. Цэвэр сайхан бичээрэй.

Сайн байна уу? Сайн байцгаана уу?



а. Уншаарай.



би	чи	та	миний
чиний	таны	намайг	чамайг
таныг	миний нэр	чиний нэр	таны нэр

б. Зааврын дагуу ярилцаарай.

Сайн байна уу?

Чиний нэр хэн бэ?

Намайг Хулан гэдэг.



Сайн, сайн байна уу?

Миний нэр Болд.

Чамайг хэн гэдэг вэ?

в. Харилцан яриаг уншаарай.



Багш

Сайн байна уу?

Чамайг хэн гэдэг вэ?

Миний нэр Дорж.

Сайн.  
Та сайн байна уу?

Намайг Бат гэдэг.  
Таны нэр хэн бэ?



Бат

г. Цэвэр сайхан бичээрэй.

Сайн байна уу? Сайн, сайн байна уу?  
Таны нэр хэн бэ? Миний нэр Дорж.  
Чамайг хэн гэдэг вэ? Намайг Бат гэдэг.

д. Дээрх өгүүлбэрээс урт, хос эгшгийг олж будаарай.



### ДАСГАЛ 3

а. Уншаарай.



нүд	чих	ам	хамар	шүд	хэл
гар	үс	би	хөл	толгой	бие

б. Өөрийн биеийн эрхтнүүдийг нэрлээрэй.

**Заавар:**


нүд		үс
чих		хамар
ам		

Энэ бол миний .....



Би бол Бат.

в. Шүлгийг тод чанга уншаарай.



**Миний бие**

Толгой минь  
 Нүд минь  
 Чих минь  
 Хамар минь  
 Ам шүд минь  
 Гар хуруу минь  
 Өвдөг хөл минь  
 Бүгдээрээ миний бие юм.

г. Бие эрхтнийг нэрлээрэй.



Энэ бол толгой.



Энэ бол шүд.



Энэ бол хэл.



Энэ бол нүд.

д. Цэвэр сайхан бичээрэй.

*нүд, чих, ам, хамар, толгой, гар, хөл, бие*



а. Уншаарай.



тэг	нэг	хоёр	гурав
дөрөв	тав	зургаа	долоо
найм	ес	арав	тоо тоолох

б. Холбоо үгийг уншаарай.



Хоёр нүд.



Хоёр чих.



Нэг ам.



Нэг хамар.



Хоёр гар.



Хоёр хөл.



Гарын арван хуруу.



Хөлийн арван хуруу.

в. Хуруу тоглоомыг тоглоорой.



Нэг хуруу, нэг хуруу  
Уул боллоо.



Хоёр хуруу, хоёр хуруу  
Нүдний шил боллоо.



Гурван хуруу, гурван хуруу  
Хорхой боллоо.



Дөрвөн хуруу, дөрвөн хуруу  
Сахал боллоо.



Таван хуруу таван хуруу  
Шувуу боллоо.

г. “Миний бие” дууг дуулж сураарай.



д. Тоонуудыг зөв дараалалд оруулж бичээрэй.

гурав

арав

нэг

зургаа

найм

хоёр

дөрөв

ес

тав

долоо



## ДАСГАЛ 5

а. Уншаарай.



эрэгтэй  
богино

эмэгтэй  
том

хүү  
жижиг

охин  
нас

урт  
настай

б. Зурагт танилцуулгыг уншаарай.




эмэгтэй  
хүүхэд

### Охин

Миний нэр Саран.  
Би долоон настай.  
Би урт үстэй.  
Жижиг нүдтэй.

### Хүү

Намайг Дөлгөөн гэдэг.  
Би найман настай.  
Би богино үстэй.  
Том нүдтэй.



эрэгтэй  
хүүхэд

в. Асуултын дагуу ярилцаарай.



- Охины нэрийг хэн гэдэг вэ?
- Тэр хэдэн настай вэ?
- Хэний үс урт вэ?
- Хүүгийн нэрийг хэн гэдэг вэ?
- Тэр хэдэн настай вэ?
- Хэний үс богино вэ?

г. Өөрийн тухай бичээрэй.

Би  
Намайг Наран гэдэг. Би долоон настай.  
Миний үс урт. Би ...



а. Үгсийг уншаарай.



Бос.

Суу.



Босоорой.

Суугаарай.



Нүдээ  
ань.



Нүдээ  
нээ.



Гараа өргөөрэй.



Алгаа ташаарай.

б. Дасгал хийгээрэй.



Алгаа ташаарай 1, 2, 3



Өвдгөө цохиорой 1, 2, 3



Хөлөө дэвсээрэй 1, 2, 3



**Заавар:** Дээрх үгсийг нэг хүүхэд хэлнэ.

Бусад нь давтан хэлээд, хөдөлгөөнийг хийнэ.

в. Өгүүлбэрийг уншаарай.

Хүүхдүүд ээ, босоорой.  
Алгаа ташаарай.  
Гараа өргөөрэй.

Хүүхдүүд бослоо.  
Хүүхдүүд алгаа ташлаа.  
Би гараа өргөлөө.

г. Өгүүлбэрийг уншаад, цэвэр сайхан бичээрэй.

*Нүдээ ань. Нүдээ нээ. Алгаа таш. Гараа өргө.*

*Алгаа ташаарай. Гараа өргөөрэй.*

*Хүүхдүүд алгаа ташлаа. Би гараа өргөлөө.*

-аарай -ээрэй -оорой -өөрэй

-лаа -лээ -лоо -лөө



## ДАСГАЛ 7

а. Онъсогыг таагаарай.



Тангадын таван хүү  
Тавуулаа нэг нэртэй.  
Тэр юу вэ?




Эгч дүү хоёулаа  
Бие биенээ үзэж  
чадахгүй.  
Тэр юу вэ?

б. Минутаар уншаарай.

гар	үс	ань	өвдөг	эрэгтэй	5
хөл	ес	хуруу	гурав	заавар	10
нүд	ам	алга	хамар	эмэгтэй	15
мөр	урт	хүзүү	толгой	хүүхдүүд	20
хэл	тоо	долоо	гэдэс	богино	25
чих	нээх	арав	өвдөх	цохих	30
мөр	шүд	зураг	зургаа	эрхтэн	35
би	нар	хоёр	дөрөв	хоёулаа	40
тав	хүү	охин	босох	танилцах	45
нэг	нас	өргө	таших	дэвсэх	50
тэр	би	хүүхэд	цэвэр	даалгавар	55
чи	суух	найм	дасгал	өгүүлбэр	60

в. Бие эрхтнийг нэрлэж бичээрэй.



# III БҮЛЭГ. ГЭР БҮЛ

## ЗУРАГТ ТОЛЬ

 <p>гэр бүл</p>	 <p>өвөө</p>	 <p>эмээ</p>	 <p>аав</p>	 <p>ээж</p>
 <p>ах</p>	 <p>эгч</p>	 <p>дүү</p>	 <p>найз</p>	 <p>гэр</p>
 <p>сайхан</p>	 <p>хөөрхөн</p>	 <p>ухаантай</p>	 <p>хүчтэй</p>	 <p>хайртай</p>
 <p>нас</p>	 <p>мод</p>	 <p>уул</p>	 <p>нар</p>	 <p>цэцэг</p>
 <p>арав</p>	 <p>хорь</p>	 <p>гуч</p>	 <p>дөч</p>	 <p>тавь</p>
 <p>жар</p>	 <p>дал</p>	 <p>ная</p>	 <p>ер</p>	 <p>зуу</p>



# ДАСГАЛ 1

## а. Уншаарай.



гэр бүл	би	аав	ээж	өвөө
эмээ	ах	эгч	дүү	хүн

## б. Зурагт танилцуулгыг уншаарай.

**Миний гэр бүл**

Энэ бол манай гэр бүл. Бид зургуулаа амьдардаг. Энэ бол би. Энэ бол миний аав ээж. Энэ бол миний дүү. Энэ миний өвөө эмээ.

Би гэр бүлдээ хайртай.

## в. Асуултын дагуу ярилцаарай.

- Чамайг хэн гэдэг вэ?
- Танай ам бүл хэд вэ?
- Хэн хэн байдаг вэ?
- Энэ хэн бэ?

**ХЭН?**  
 аав  
 ээж  
 өвөө  
 эгч

## г. Зааврын дагуу танилцуулга бичээрэй.

**Түлхүүр үгс:** аав, ээж, ах, эгч, дүү, эмээ, өвөө

**Заавар:**

*Намайг Айна гэдэг. Энэ миний аав.*



## а. Уншаарай.



Дондог  
Саруул

Дулмаа  
Хаш

Сүхээ  
Гэрэлмаа

## б. Харилцан яриаг уншаарай.



Энэ хэн бэ?

Чиний аавын нэр хэн бэ?

Танай ээжийг хэн гэдэг вэ?

Энэ чиний эмээ юу?

Энэ миний аав.

Миний аавын нэр Сүхээ.

Миний ээжийг Гэрэлмаа гэдэг.

Тийм ээ, энэ миний эмээ.



## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Тэр хэний гэр бүл вэ?
- Батын ам бүл хэд вэ?
- Батын аавын нэр хэн бэ?
- Бат эмээтэй юу?



Хүний нэрийг том үсгээр эхэлж бичнэ.

**Дулмаа, Сүхээ**

## г. Цэвэр сайхан бичээд, эгшгийг улаан, гийгүүлэгчийг цэнхэр өнгөөр будаарай.

Өвөөгийн нэрийг Дондог гэдэг.

Эмээгийн нэрийг Дулмаа гэдэг.

Аавын нэрийг Сүхээ гэдэг.

Ээжийн нэрийг Гэрэлмаа гэдэг.

Ахын нэрийг Хаш гэдэг.



## ДАСГАЛ 3

а. Уншаарай.



арав хорь гуч дөч тавь жар дал ная ер зуу








б. 1-ээс 100 хүртэл тоолж сураарай.

1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21,  
22, ... 30, ... 40, ... 50, ... 60, ...,70, ... 80, ... 90, ... 100

*Нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаа, долоо, найм, ес, арав, арван  
нэг, арван хоёр, арван гурав, арван дөрөв, арван тав, арван  
зургаа, арван долоо, арван найм, арван ес, хорь, хорин нэг, хорин  
хоёр, ... гуч, ... дөч, ... тавь, ... жар, ... дал, ... ная, ... ер, ... зуу*



в. Эхийг уншаарай.

### Манай гэр бүл

Бид наймуулаа амьдардаг. Эмээ, өвөө, аав, ээж, ах, эгч,  
дүүтэйгээ.  хоёр далан настай. Миний  гучин есөн  
настай.  гучин долоон настай. Ах  арван таван настай.   
арван настай.  найман настай. Миний  таван настай.

г. Асуултын дагуу ярилцаарай.





 Тэр хэдүүлээ амьдардаг вэ?  
 Хэн хэдэн настай вэ?



хэд?  
тав  
арав  
гучин нэг  
зуу

д. Асуултад хариулж, дэвтэртээ бичээрэй.



 Чи хэдүүлээ амьдардаг вэ?  
 Чиний эмээ, өвөө, аав, ээж, ах, эгч, дүү хэдэн настай вэ?



## а. Уншаарай.



ханагар уул  
гоёхон цэцэг

алтан нар  
бөжин туулай

ургаа мод  
барын бамбар

## б. Шүлгийг тод чанга уншаарай.

### Гэр бүл

Аав минь гэртээ ханагар уул  
Ээж минь гэртээ алтан наран  
Ах минь гэртээ ургaa мод  
Эгч минь гэртээ гоёхон цэцэг  
Дүү минь гэртээ бөжин туулай  
Би өөрөө ганган эрвээхэй  
(Би өөрөө барын бамбар)



## в. Холбоо үг, өгүүлбэрийг уншаад дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.

ахын дүү  
эгчийн дүү  
дүүгийн эгч  
дүүгийн ах

аавын хүү  
аавын охин  
ээжийн хүү  
ээжийн охин

Миний

аав хүчтэй.  
ээж ухаантай.  
дүү хөөрхөн.  
эгч сайхан.

## г. Өөрийнхөө гэр бүлийн зургийг дэвтэртээ зураарай.



аавын  
ээжийн  
ахын  
эгчийн  
өвөөгийн  
эмээгийн  
дүүгийн



## ДАСГАЛ 5

а. Уншаарай.



чулуу



шулуун



Чулуун

б. Эхийг уншаарай.



### Миний найз

Миний найзыг Чулуун гэдэг. Чулууны аавын нэр Дондог. Чулуун долоон настай. Тэр хоёрдугаар ангид сурдаг. Чулуун ухаантай хүүхэд. Би найздаа хайртай.

в. Асуултын дагуу ярилцаарай.



- Чулууны найзын нэр хэн бэ?
- Чулуун хэдэн настай вэ?
- Чулуун хэддүгээр ангид сурдаг вэ?
- Чи найзтай юу? Найзынхаа тухай ярилцаарай.

г. Шүлгийг чанга тод уншиж, цээжлээрэй.

### Гурван эрдэнэ

Алт гэвэл аавыг хэлнэ

Энгүй сайхан сэтгэлийг хэлнэ.

Ачтай сайхан итгэлийг хэлнэ.

Нандин гэвэл найзаа хэлнэ

Эрдэнэ гэвэл ээжийг хэлнэ

Намайг гэсэн бодлыг хэлнэ.

д. Шүлгийг цэвэр сайхан бичээрэй. Эгшиг үсгийг улаанаар, гийгүүлэгчийг цэнхэр өнгөөр будаарай.

# IV БҮЛЭГ. СУРГУУЛЬ, АНГИ

## ЗУРАГТ ТОЛЬ



цүнх



дэвтэр



үзэг



шугам



баллуур



цавуу



хайч



бийр



НОМ,  
сурах бичиг




зургийн дэвтэр



усан будаг



үзэг  
харандааны  
сав




харандаа  
үзүүрлэгч



харандаа



ӨНГИЙН  
цаас



хаяг



хуудас



өнгө



шар



ногоон



цэнхэр



хөх



цагаан



ягаан



бор



хар



улаан



нил ягаан



саарал



хэлбэр дүрс




гурвалжин




дөрвөлжин



дугуй



тууш шугам




ташуу зураас



сургууль




анги




номын сан



биеийн  
тамирын заал




цайны газар



самбар




цонх



хөшиг



барил




багшийн ширээ



сурагчийн  
ширээ, сандал



шүүгээ



тавиур



зурагт



цаг



гэрэл, чийдэн




унтраалга




өлгүүр



хаалга




түлхүүр




цоож



хогийн сав



шал



тааз



хана




зурах



будах




наах



хайчлах




баллуурдах



өгөх




авах



асуух



хариулах



бичих, унших



а. Уншаарай.



ном	дэвтэр	үзэг	харандаа
бийр	цүнх	шугам	үзүүрлэгч
хайч	цавуу	баллуур	үзэгний сав

б. Уншаарай. Харилцан ярилцаарай.



Энэ юу вэ?

Чамд дэвтэр байна уу?

Тэр хэний дэвтэр вэ?

Энэ бол дэвтэр.

Байгаа.  
Энэ миний дэвтэр.

Тэр Айдосын дэвтэр.



в. Зургийн дагуу өгүүлбэр зохиогоорой.



**Заавар:**

- Энэ бол шугам. Энэ миний шугам.
- Тэр бол шугам. Тэр түүний шугам.




## ДАСГАЛ 2

а. Уншаарай.




шар	хөх	ягаан	бор
улаан	ногоон	цэнхэр	хар
цагаан	өнгө	усан будаг	өнгийн цаас


б. Шүлгийг тод чанга уншаарай.



в. Тааврыг таагаарай.



г. Холбоо үг бүтээж бичээрэй.



д. Өгүүлбэр зохиож бичээрэй.



**Заавар:** Надад ногоон өнгийн харандаа бий.




а. Уншаарай.




дүрс      дугуй      гурвалжин      дөрвөлжин      бичих  
 будах      зурах      наах      хайчлах      баллуурдах

б. Холбоо үг, өгүүлбэр бүтээгээрэй.



**Заавар:** Эгч дугуй дүрс хайчлав.

в. Үйл явдлын дарааллыг олж, ярилцаарай.



г. Уншаад, үйл хөдлөлөөр илэрхийлээрэй.

Үзгээр бичээрэй.  
 Харандаагаар зураарай.  
 Бийрээр будаарай.  
 Хайчаар хайчлаарай.  
 Цавуугаар наагаарай.  
 Баллуураар баллуурдаарай.



- аарай  
 - ээрэй  
 - оорой  
 - өөрэй

д. Дээрх өгүүлбэрийг дэвтэртээ бичээрэй. Урт эгшгийг улаанаар, хос эгшгийг ногоон өнгөөр будаарай.



## ДАСГАЛ 4


а. Уншаарай.



бид	манай	анги	цонх	хаалга
баруул	шал	тааз	хана	самбар
ширээ	сандал	шүүгээ	тавиур	цаг

б. Зургийг хараад асуултын дагуу ярилцаарай.

### Анги



- Ангид хэн, хэн байна вэ?
- Хэдэн хүүхэд байна вэ?
- Ангид юу, юу байна вэ?
- Самбар ямар өнгөтэй вэ?
- Анги хэдэн цонхтой вэ?



хэн?  
юу?  
ямар?  
хэд?

в. Асуултад тохирох тус бүр 2 үг олж бичээрэй.

хэн?

юу?

ямар?

хэд?

г. Эхийг дэвтэртээ цэвэр, сайхан бичээрэй.

### Манай анги

Манай анги том. Гурван цонхтой. Нэг хаалгатай. Ангид самбар, ширээ, сандал, шүүгээ бий. Манай багшийн нэр Болормаа. Анги хорин дөрвөн сурагчтай. Бид ангидаа хайртай.



## а. Уншаарай.



мөн биш тийм үгүй гэрэл унтраалга  
зураг зурагт хөшиг хогийн сав цоож түлхүүр

## б. Харилцан ярилцаарай.



Энэ цонх мөн үү?

Тийм ээ, тэр цонх мөн.



Тийм ээ, мөн.



Тэр гэрэл мөн үү?



Үгүй, тэр гэрэл биш, цаг.



Үгүй, биш.

## в. Үгсийг ашиглан харилцан ярилцаарай.

багш  
сурагч  
хүү  
охин

ширээ  
тавиур  
унтраалга  
хогийн сав

Тийм ээ, мөн.

Үгүй, биш.

## г. Өгүүлбэрийг дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.

 самбар байна. Надад  үзэг бий.

Ангийн хөшиг  өнгөтэй. Сурагчийн ширээ  өнгөтэй.



## ДАСГАЛ 6

а. Уншаарай.



сум	сургууль	сурах	аль
олон	давхар	нэгдүгээр	хоёрдугаар
гуравдугаар	номын сан	цайны газар	биеийн тамирын заал

б. Эхийг уншаарай.



### Сургууль

Би Өлгий сумын аравдугаар сургуульд сурдаг. Сургууль хоёр давхар байшинтай. Манай анги нэгдүгээр давхарт байдаг. Сургуульд олон хүүхэд сурдаг. Цайны газар, биеийн тамирын заал, номын сан бий. Бид сургуульдаа хайртай.

в. Асуултын дагуу ярилцаарай.



- Тэр аль сургуульд сурдаг вэ?
- Сургуульд юу юу байдаг вэ?
- Сургуульд хэн сурдаг вэ?

г. Хүүхдүүдийн яриаг дэвтэртээ бичээрэй.

Чи аль сургуульд сурдаг вэ?



Би Өлгий сумын нэгдүгээр сургуульд сурдаг.



а. Уншаарай.



тууш	ташуу	тооны	хаяг
хуудас	хавтас	Баян-Өлгий аймаг	
Ногооннуур сум		Ерөнхий боловсролын сургууль	

б. Харилцан яриаг уншаарай.

Энэ ямар дэвтэр вэ?



Тэр бол дөрвөлжин шугамтай дэвтэр.

Энэ бол тууш шугамтай дэвтэр.


Энэ бол ташуу шугамтай дэвтэр.

в. Холбоо үг, өгүүлбэр бүтээгээрэй.

тууш  
дөрвөлжин  
ташуу

→

шугамтай дэвтэрт бичлээ.



г. Загварын дагуу дэвтрийн хаяг бичээрэй.

**Заавар:**

**ДЭВТЭР**

*Монгол хэл  
Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2б ангийн сурагч  
Д. Бат*

Д.Бат Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2б ангид сурдаг.

д. Таавар зохиогоорой.



**Заавар**

**Таавар**  
Тэр олон хуудастай.  
Чи түүн дээр бичдэг.  
Тэр юу вэ?

Тэр бол





## ДАСГАЛ 8

а. Уншаарай.



авах

өгөх


жаахан

ухаантай

магтах

баярлах

а. Эхийг уншаарай.



### Ухаантай охин

Ээж нь охиндоо ном авч өгөв. Охин минь, чамайг жаахан байхад эмээ чинь ном уншиж өгдөг байсан. Одоо чи том болсон. Эмээдээ ном уншиж өгөөрэй гэв. Охин эмээдээ ном уншиж өглөө.

Ээж нь баярлаж Манай охин ямар ухаантай юм бэ? гэж магтав.

б. Үйл явдлын дэс дарааллыг олж, яриарай.



в. Эхээс асуултад тохирох үгсийг олж бичээрэй.



**Заавар:**

Ээж

өгөв.

Хэн?

юу хийсэн бэ?

г. Асуух өгүүлбэр зохиож, асуултад хариулаарай.

Хэн



өгсөн бэ?

авсан бэ?

уншсан бэ?

д. Асуулт, хариултаа дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.

# V БҮЛЭГ. АЖИЛ ХӨДӨЛМӨР

## ЗУРАГТ ТОЛЬ

					
7 хоног	өчигдөр	өнөөдөр	маргааш	өглөө	өдөр
					
орой	шөнө	хичээл	хичээлийн хуваарь	тооны хичээл	монгол хэл
					
хүн ба орчин	хөгжим	дүрслэх урлаг, технологи	иргэний ёс зүйн боловсрол	дуртай	дургүй
					
дуулах	хөгжим тоглох	бүжиглэх	тоо бодох	дасгал хийх	тоглох
					
ярих	цээжлэх	чөлөөт цаг	дугуйлан	шатар	даам
					
үлгэр	шүлэг	амрах	хичээл давтах	ирэх	очих
					
явах	унтах	цай уух	хоол идэх	цэвэрлэх	угаах



# ДАСГАЛ 1

## а. Уншаарай.



Даваа  
Бямба

Мягмар  
Ням

Лхагва  
өчигдөр

Пүрэв  
өнөөдөр

Баасан  
маргааш

## б. Шүлгийг тод чанга уншаарай.

### Долоо хоног

Нэг хоёр, нэг хоёр  
Нэг хоёр гурав  
Найз аа! Найз аа!  
Намайг дагаад хэлээрэй  
**Даваа, Мягмар, Лхагвад**  
Дандаа эмээгийнд очно.

Харин **Пүрэв, Баасанд**  
Харьж гэртээ ирнэ  
Амралтын **Бямба, Нямд**  
Айлын хүүхдүүдтэй тоглоно  
Эхнээс нь дахиад хэлээрэй  
Энэ тооллыг давтаарай

## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүү эмээгийндээ хэзээ очдог вэ?
- Хүү хэзээ гэртээ ирдэг вэ?
- Тэр бямба, нямд юу хийдэг вэ?
- Өнөөдөр ямар гараг вэ?
- Маргааш ямар гараг вэ?
- Өчигдөр ямар гараг байсан бэ?




хэн?  
хэзээ?  
яав?

## г. Шүлгийг цээжээр уншаарай.

Даваа, Мягмар, Лхагвад

Пүрэв, Баасанд

Бямба, Нямд



## д. Өгүүлбэрийг зөв дараалалд оруулж дэвтэртээ бичээрэй.



Айлын хүүхдүүдтэй тоглоно.  
Би эмээгийнд очно.  
Пүрэв, баасанд гэртээ ирнэ.



## а. Уншаарай.



хичээл

Математик

Хүн ба орчин

хичээлийн хуваарь

Хөгжим

Биеийн тамир

Монгол хэл

Дүрслэх урлаг, технологи

Иргэний ёс зүйн боловсрол

## б. Харилцан яриаг уншаарай.



Хичээлдээ юу юу авч явах вэ?

Өнөөдөр юу орох вэ?

Аа, мэдлээ. Хичээлийн хуваариа харъя.



Өнөөдөр орох хичээлээ ялгаарай.

Хичээлийн хуваарь гэж байдаг шүү дээ!



Өнөөдөр мягмар гараг. Монгол хэл, математик, хөгжим, зургийн хичээл орох юм байна шүү!

### Мягмар

1. Монгол хэл
2. Математик
3. Хөгжим
4. Дүрслэх урлаг

## в. Ярилцаарай.



- Өнөөдөр ямар гараг вэ?
- Ямар, ямар хичээл орох вэ?
- Хүү хичээлдээ юу юу авч явах вэ?



## г. Маргаашийн хичээлийн хуваариа дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.



## ДАСГАЛ 3

а. Уншаарай.



дуртай

хөгжим тоглох

дургүй

бөмбөг тоглох

дуулах

дасгал хийх

бүжиглэх

тоо бодох

б. Эхийг уншаарай.

### Сургууль дээр

Багш хичээл заана.



Монгол хэлний хичээл дээр уншина, сонсоно, бичнэ, ярина.

Тооны хичээл дээр тоолно, тоо бодно.



Зургийн хичээл дээр зураг зурна, наана, хайчилна, будна.

Хөгжмийн хичээл дээр дуулна, бүжиглэнэ, хөгжим тоглоно.



Биеийн тамирын хичээл дээр тоглоно. Дасгал хийнэ.



в. Асуултын дагуу ярилцаарай.



- Та нарт ямар, ямар хичээл ордог вэ?
- Ямар хичээл дээр юу хийдэг вэ?
- Чи сургууль дээр юу хийж сурсан бэ?
- Чи ямар хичээлд дуртай вэ?

г. Өгүүлбэрийг уншаад, дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.

Би

уншиж  
тоо бодож  
дуу дуулж

чадна.



а. Уншаарай.



үлгэр	шүлэг	шатар	даам
дугуйлан	чөлөөт цаг	ярих	цээжлэх

б. Эхийг уншаарай.

**Найз**

Миний найзыг Цолмон гэдэг. Бид хоёр нэг ангид сурдаг. Би ном унших дуртай. Олон үлгэр, шүлэг сурсан. Цолмон шатар тоглох дуртай. Тэр бямба, ням гарагт шатрын дугуйланд явдаг. Бид чөлөөт цагаараа шатар, даам тоглодог.



в. Асуултын дагуу ярилцаарай.




- Түүний сайн найзыг хэн гэдэг вэ?
- Тэр юу хийх дуртай вэ?
- Түүний найзын хийх дуртай зүйл юу вэ?
- Тэр хэзээ дугуйланд явдаг вэ?
- Тэд чөлөөт цагаараа юу хийдэг вэ?
- Тэд бас юу хийж магадгүй вэ?

г. Зургаан үг олж уншаад, бичээрэй.

уншаарай бүжиглээрэй зураарай бичээрэй дуулаарай тоглоорой дуулаарай

д. Өгүүлбэрийг уншаад, дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.





## ДАСГАЛ 5

### а. Уншаарай.



өглөө  
амрах  
цай уух

өдөр  
үзэх  
хоол идэх

орой  
харах  
угаах

шөнө  
ирэх  
цэвэрлэх


унтах  
явах  
туслах

### б. Эхийг уншаарай.




#### Чи өглөө юу хийдэг вэ?

Би өглөө найман цагт босдог. Нүүр гараа угаадаг. Бас шүдээ угаадаг. Дасгал хийдэг. Цайгаа уугаад, сургуульдаа явдаг.



#### Чи өдөр юу хийдэг вэ?



Би сургуулиас ирээд, өдрийн хоолоо иддэг. Гэрийн даалгавраа хийдэг. Ном уншиж, зураг зурна. Бас тоглоно.



#### Чи орой юу хийдэг вэ?

Оройн хоолоо иддэг. Аав ээждээ тусалдаг. Зурагт үзнэ. Шөнө унтаж амарна.



### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Та нар өдөр бүр юу хийдэг вэ?
- Сургуульдаа хэзээ явдаг вэ?



-даг -на  
-дэг -нэ  
-дог -но  
-дөг -нө

### г. Өгүүлбэр зохиож бичээрэй.





а. Уншаарай.



баяртай	хөгжилтэй	жаргалтай	олуулаа
жаалууд	багачууд	авьяастай	авхаалжтай

б. Шүлгийг уншаад, дуулж сураарай.

**Олуулаа**



Хүүхдүүд бид нар сургууль дээрээ  
 Хөгжилтэйхэн байдаг даа  
 Олуулаа бид дуулдаг даа  
 Олуулаа бид бүжиглэдэг  
 Олуулаа, олуулаа, олуулаа  
 Багачууд бид нар сургууль дээрээ  
 Баяртайхан байдаг даа  
 Олуулаа бид уншдаг даа  
 Олуулаа бид хөгжимддөг  
 Олуулаа, олуулаа, олуулаа  
 Жаалууд бид нар сургууль дээрээ  
 Жаргалтайхан байдаг даа  
 Олуулаа бид авьяастай  
 Олуулаа бид авхаалжтай  
 Олуулаа, олуулаа, олуулаа

*Д. Содномдорж*

в. Асуултын дагуу ярилцаарай.



- Та нар сургууль дээрээ юу хийдэг вэ?
- Хэн ямар авьяастай вэ?
- Сургууль дээрээ байх сайхан уу? Яагаад?
- Дуугаа дуулж сурсан уу?

г. Өгүүлбэрийг уншаад, дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.

Хүүхдүүд

хөгжилтэй  
 баяртай  
 жаргалтай

байна.



# ДАСГАЛ 7

## а. Уншаарай.



баяртай  
хөгжилтэй

гунигтай  
уйтгартай

тайван  
уйлах

ууртай  
инээх

## б. Харилцан яриаг уншаарай.



Багш

Хүүе ээ, яасан бэ?

Чи уйлж байна уу даа?

Миний хөл өвдөж байна.

Үгүй ээ, уйлаагүй.



Хүү

## в. Асуултын дагуу ярилцаарай.



Хүүгийн юу өвдсөн бэ?

Тэр уйлсан уу?

## г. Зургуудийг ажиглаад тохирох дүрсийг дэвтэртээ зураарай.



баяртай



ууртай



гунигтай



хөгжилтэй



уйтгартай

## д. Өгүүлбэрийг уншаад, дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.

Миний

толгой

шүд

гэдэс

өвдөж байна.

Миний дүү

уйлж

инээж

уурлаж

байна.

# VI БҮЛЭГ. БИДНИЙ ОРЧИН

## ЗУРАГТ ТОЛЬ



хот



орон сууц



хөдөө



аймаг, дүүрэг




сум, баг



гудамж



талбай



байшин



дээвэр



яндан



зочны өрөө




унтлагын өрөө



гал тогооны өрөө



угаалгын өрөө



хивс



буйдан



авдар



ор



дэр



толь



угаалтуур



шүршүүр



суултуур



хөргөгч



цахилгаан зуух



тогоо



аяга



таваг



хажууд



дунд, голд



зүг чиг



хойд



урд



баруун



зүүн



# ДАСГАЛ 1

## а. Уншаарай.



манайх  
орон сууц

амьдрах  
модон хашаа

дээвэр  
ирэх

байшин  
очих

## б. Уншаад, харилцан ярилцаарай.



Бат

Сайн уу? Хулан.

Чи манайд ирж байна уу?

Цэнхэр өнгийн хаалгатай,  
модон хашаа байгаа.

Тийм ээ, мөн.



Хулан


Сайн. Сайн уу?

Тийм ээ, очиж байна.  
Танайх ямар хашаатай вэ?

Улаан дээвэртэй, шар  
өнгөтэй байшин мөн үү?

За, ирчихлээ.

## в. Өгүүлбэрийг холбож уншаарай.



## г. Үгсээр өгүүлбэр бүтээж дэвтэртээ бичээрэй.

хаана

Чи

амьдардаг

вэ?

амьдардаг.

орон

сууцанд

Би



## а. Уншаарай.



зочны өрөө  
дотуур байр

унтлагын өрөө  
угаалгын өрөө

гал тогооны өрөө  
хүүхдийн өрөө

## б. Эхийг уншаарай.



### Манай байшин

Манайх байшинд амьдардаг. Манай байшин таван өрөөтэй. Зочны өрөө, гал тогооны өрөө, угаалгын өрөө, унтлагын өрөө, хүүхдийн өрөө бий. Зочны өрөөнд зурагт үздэг. Гал тогооны өрөөнд хоол хийдэг. Бид унтлагын өрөөндөө унтдаг. Угаалгын өрөөнд гар нүүрээ угаадаг.

## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Тэр хаана амьдардаг вэ?
- Тэдний байшин хэдэн өрөөтэй вэ?
- Тэр зочны өрөөндөө юу хийдэг вэ?
- Гал тогооны өрөөнд юу хийдэг вэ?
- Тэр аль өрөөнд унтдаг вэ?
- Тэр аль өрөөнд тоглодог вэ?

## г. Өөрийн амьдардаг сууцны тухай бичээрэй.



## ДАСГАЛ 3

### а. Уншаарай.



ор	дэр	толь	буйдан	хивс
тоглоом	аяга	таваг	тогоо	угаалтуур
шүршүүр	суултуур	хөргөгч	хөлдөөгч	цахилгаан зуух

### б. Өрөөний доторх зүйлсийг нэрлээрэй.




хаана, юу  
байна вэ?

### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Зочны өрөөнд юу юу байна вэ?
- Буйдан ямар өнгөтэй вэ?
- Хэний өрөөнд ор байна вэ?
- Хэдэн ор байна вэ?
- Цахилгаан зуух хаана байна вэ?
- Угаалтуур аль өрөөнд байна вэ?

### г. Үг бүтээж дэвтэртээ бичээрэй.






а. Уншаарай.



Шагдар байшин шар шөнө шилэн

б. Шүлгийг тод чанга уншаарай.


Шөнийн байшин



Шагдар хүү

байшин


зуржээ.



Шар өнгийн

байшин


зуржээ.



Шагдар хүүгийн

зурсан


байшин



Шилэн цонхгүй

байшин

байлаа.



Шилэн цонхгүй

байшин уу?

гэтэл



Шөнө юм чинь гэж

Шагдар

хариуллаа.

Ш.Энхбаяр

в. Асуултын дагуу ярилцаарай.



Шагдар ямар байшин зурсан бэ?

Ямар цонх зурсан бэ? Яагаад?



## ДАСГАЛ 5

### а. Уншаарай.



хот  
дүүрэг

хөдөө  
баг

гудамж  
хороо

талбай  
мэднэ

аймаг  
мэдэхгүй

### б. Ярилцаарай.



Бат

Чи гэрийнхээ  
хаягийг мэдэх үү?

Би сайн мэдэхгүй  
байна.  
Аав ээжээс асууя.



Хулан

### в. Эхийг уншаарай.



Манайх Баян-Өлгий  
аймгийн Буянт сумын  
1 дүгээр багт амьдардаг.



**Хулангийн гэрийн хаяг:**

**Аймаг:** Баян-Өлгий аймаг

**Сум, баг:** Буянт сумын 1 дүгээр баг

**Хаалга:** 17-25 тоот



Би Улаанбаатар хотын  
Баянгол дүүргийн, 3 дугаар  
хороонд амьдардаг.




**Батын гэрийн хаяг:**

**Хот:** Улаанбаатар хот

**Дүүрэг:** Баянгол дүүрэг

**Хаалга:** 6-63 тоот



### д. Өөрийн гэрийн хаягаа бичээрэй.



## а. Уншаарай.



баруун  
урд

зүүн  
зүг чиг


хойд  
хаяг байршил

## б. Эхийг уншаарай.



Бат, Хулан, Цэцэг, Болд дөрөв найзууд.

- Батынх талбайн хойд талд байна.
- Болдынх талбайн зүүн талд байна.
- Цэцэгийнх талбайн урд талд байна.
- Хулангийнх талбайн баруун талд байна.



## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хэн хэн найзууд вэ?
- Тэдний гэр талбайн аль аль талд байна вэ?
- Талбай тэдний гэрийн аль талд байна вэ?



## ДАСГАЛ 7

а. Уншаарай.



зуух  
дотор


яндан  
голд

авдар  
дунд

хоймор  
дээр

хажууд  
доор


б. Эхийг уншаарай.



### Гэр

Манай гэр таван ханатай. Гэрийн хойморт хоёр авдар байна. Авдрын хажууд том шүүгээ бий. Гэрийн голд зуух байна.

в. Зургийн дагуу ярилцаарай.



Гэр дотор юу юу байна вэ?



Хаана юу байна вэ?



**Заавар:** Зуухны баруун талд ор байна. Орны хажууд авдар байна.

г. Өгүүлбэрийг уншаад, дэвтэртээ бичээрэй.



Хүү сандал дээр сууж байна.

Охин ширээн доор байна.

# VII БҮЛЭГ. ХООЛ ХҮНС

## ЗУРАГТ ТОЛЬ



мах



хиам



өндөг



гурил



талх



боорцог



шөл



бууз



хуушуур



бялуу



зайрмаг



давс



чихэр



жигнэмэг



шоколад



сүү



тараг



айраг



цай



ус



жүүс, ундаа



төмс



байцай



луван



сонгино



манжин



алим



жүрж



гадил



тарвас



усан үзэм



цэвэр



бохир



саван



алчуур



арчих



тогооч



амттай



гашуун



дээр



доор



дотор



# ДАСГАЛ 1

## а. Уншаарай.



хоол  
зайрмаг

хүнс  
өндөг

талх  
хиам

боорцог  
чихэр

бялуу  
жигнэмэг

## б. Харилцан яриаг уншаарай.



- Сайн байна уу? Эгч ээ. Бялуу байна уу?
- Үгүй ээ, байхгүй.
- Жигнэмэг байна уу?
- Жигнэмэг байна.
- Жигнэмэг ямар үнэтэй вэ?
- Жигнэмэг 800 төгрөг.
- Нэг жигнэмэг авъя.

800 - найман зуу

## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Бат хаана очсон бэ?
- Бат юу худалдаж авсан бэ?
- Жигнэмэг ямар үнэтэй вэ?

## г. Өгүүлбэрийг уншаарай.

Бат




- иднэ.
- идэж байна.
- идэв.

Би



- идмээр байна.
- идлээ.
- идсэн.

## д. Зургийг ашиглан өгүүлбэр зохиож дэвтэртээ бичээрэй.





## а. Уншаарай.



сүү  
шөл

тараг  
айраг

ус  
жүүс

ундаа  
хайрцаг

цай  
давс

## б. Өгүүлбэрийг уншаарай.



- Хөргөгчинд сүү байна.
- Цахилгаан зуухан дээр шөл байна.
- Хайрцаг дотор ус байна.
- Ширээн дээр цай байна.

## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хөргөгчинд юу байна вэ?
- Ус хаана байна вэ?
- Зуухан дээр юу байна вэ?
- Ширээн дээр юу байна вэ?

## г. Зургийн дагуу ярилцаж, өгүүлбэр зохиогоорой.



**Түлхүүр үгс:** дээр, доор, дотор, хажууд

## д. Үгсийг ашиглан өгүүлбэр зохиогоорой.





## ДАСГАЛ 3

а. Уншаарай.



амттай  
чихэртэй

гашуун  
шоколадтай

цөцгийтэй  
боовон торхтой

б. Уншаад, дуулж сураарай.

### Зайрмаг

Цөцгийтэй сүүгээр хийсэн  
Чихэр жимсээр амталсан  
Боовон торхтой зайрмагт  
Багачууд бид нар хэчнээн дуртай гээч  
Чихэртэй зайрмаг  
Цөцгийтэй зайрмаг  
Шоколадтай зайрмаг  
Би ч дуртай  
Чи ч дуртай  
Бүгдээрээ дуртай.



в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүүхдүүд юунд дуртай вэ?
- Ямар, ямар зайрмаг байдаг вэ?
- Чи ямар зайрмагт дуртай вэ?

г. Өгүүлбэрүүдийг зөв дараалуулж дэвтэртээ бичээрэй.

### Зайрмаг

Зайрмаг амттай байв. Тэр шоколадтай зайрмаг авлаа. Золбоо зайрмаг авахаар дэлгүүрт орлоо. Золбоо зайрмагт дуртай.

д. Үгсийг дэвтэртээ бичээд, хос эгшгийн доогуур зураарай.

Амттай, сүүтэй, аарцтай, чихэртэй,  
цөцгийтэй, шоколадтай



а. Уншаарай.



жимс, ногоо  
манжин

төмс  
жүрж





байцай  
гадил

лууван  
усан үзэм

сонгино  
тарвас

б. Эхийг уншаарай.





**Дэлгүүр**

Энхээ жимс, ногооны дэлгүүрт очлоо. Дэлгүүрт олон жимс, ногоо байлаа. Тэр , , , , бас ногоо авлаа. Жимсээ амтархан идлээ. Авсан ногоогоор амттай хоол хийлээ.



в. Асуултын дагуу ярилцаарай.



-  Энхээ хаана очсон бэ?
-  Дэлгүүрт юу, юу байсан бэ?
-  Тэр ямар, ямар жимс авсан бэ?
-  Ногоогоор юу хийсэн бэ?

г. Харилцан ярилцаарай.

Ямар  бэ?

Ямар  вэ?

Ямар  бэ?




Улаан лууван.

Шар манжин.

Ногоон сонгино.

д. Холбоо үг үүсгээд, өгүүлбэр зохиогоорой.

Ямар?



Ямар?





## ДАСГАЛ 5

а. Уншаарай.



бууз  
үдийн хоол

хуушуур  
тогооч

мах  
чацаргана

гурил  
хооллох

б. Эхийг уншаарай.

### Сургуулийн үдийн хоол

Үдийн цайны цаг боллоо.

Тогооч амттай бууз, чацарганы ундаа өгөв. Тэр "Тавтай сайхан хооллоорой" гэж хэлэв. Амттай хоол хийж өгсөн тогооч эгчдээ баярлалаа. Бид үдийн цайны дараа ширээгээ цэвэрлэв.



в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүүхдүүд хаана хооллосон бэ?
- Хэн амттай хоол өгсөн бэ?
- Хүүхдүүд ямар хоол идсэн бэ?
- Тогооч хүүхдүүдэд юу гэж хэлсэн бэ?
- Хүүхдүүд тогооч эгчид юу гэж хэлсэн бэ?
- Та нар үдийн хоолондоо юу иддэг вэ?
- Яагаад хоол идэх хэрэгтэй вэ?

г. Тогооч хүү хоёрын яриаг дэвтэртээ бичээрэй.



Тавтай сайхан  
хооллоорой.



Тогооч эгчдээ  
баярлалаа.

д. Өгүүлбэрээс урт эгшгийг олж будаарай.

Бууз, хуушуурыг мах, гурилаар хийдэг.



## а. Уншаарай.



цэвэр  
дараа

бохир  
норгох

саван  
арчих

алчуур  
хөөсрүүлэх

өмнө  
бие засах

## б. Зурагт эхийг уншаарай.



### Гар угаах дараалал

1. Гараа усаар норгоно.
2. Савандана.
3. Хөөсрүүлэн угаана.
4. Савангаа арилгана.
5. Алчуураар арчина.

## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Гар угаахад юу, юу хэрэгтэй вэ?
- Гараа яаж угаах вэ?
- Гарыг ямар дарааллаар угаах вэ?
- Угаасан гар ямар байдаг вэ?
- Гараа хэзээ угаах вэ?
- Гарыг яагаад угаах ёстой вэ?

## г. Өгүүлбэрийг уншаад дэвтэртээ бичээрэй.


Хоол идэхийн өмнө

Гаднаас орж ирээд

Бие зассаны дараа

Тоглосны дараа

гараа угаана.





## ДАСГАЛ 7

а. Зургийн үйл явдлыг ажиглаарай.



б. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүүхдүүд хаана байна вэ?
- Цайны газарт хэдэн хүүхэд байна вэ?
- Хүүхдүүд юу хийж байна вэ?
- Бүх хүүхэд ундаа авсан уу?
- Хэдэн хүүхэд зайрмаг идэж байна вэ?
- Хүүхдүүд баяртай байна уу?
- Хүү тогоочид юу гэж хэлсэн бэ?
- Тогооч юу гэж хариулсан бол?

в. Хоол хүнсний нэрийг заасан 5 үг бичээд, авиа үсгийн тоог олоорой.



**Заавар:**

Ундаа - 5 үсэг, 4 авиа

г. Асуултад тохирох өгүүлбэр зохиож дэвтэртээ бичээрэй.



**Заавар:**

хэн?

юуг?

яав?

Ээж

хоол

хийв.

# VIII БҮЛЭГ. АМЬТАД

## ЗУРАГТ ТОЛЬ



хонь



ямаа



үхэр



адуу



тэмээ



хурга



ишиг



тугал



унага



ботго



нохой



муур



тахиа



туулай



гахай



заан



баавгай



чоно



үнэг



арслан



бар



бүргэд



хэрэм



зараа



могой



хулгана



болжмор



шар шувуу



загас



шоргоолж



## ДАСГАЛ 1

### а. Уншаарай.



мал	төл	адуу	унага	тэмээ	ботго
хонь	хурга	ямаа	ишиг	үхэр	тугал

### б. Зурагт эхийг уншаарай.

 -ны төлийг  гэнэ.  
 -ний төлийг  гэнэ.  
 -ны төлийг  гэнэ.  
 -ны төлийг  гэнэ.  
 -ийн төлийг  гэнэ.

### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Адууны төлийг юу гэдэг вэ?
- Тэмээний төлийг юу гэдэг вэ?
- Хонины төлийг юу гэдэг вэ?
- Үхрийн төлийг юу гэдэг вэ?
- Ямааны төлийг юу гэдэг вэ?


### г. Үгсийг зөв байрлуулж, өгүүлбэр зохиож бичээрэй.



1. төлийг, гэнэ, хурга, Хонины.
2. Адууны, гэнэ, төлийг, унага.
3. гэнэ, Үхрийн, тугал, төлийг.
4. Ямааны, ишиг, төлийг, гэнэ.
5. ботго, төлийг Тэмээний, гэнэ.



а. Холбож уншаарай.



б. Эхийг уншаарай.

### Төл мал

Үхэр тугаллав. Тугал төрлөө.  
 Адуу унагалав. Унага төрлөө.  
 Хонь хургалав. Хурга төрлөө.  
 Ямаа ишиглэв. Ишиг төрлөө.  
 Тэмээ ботголов. Ботго төрлөө.  
 Тугал мөөрнө. Унага янцгаана.  
 Хурга ишиг майлна. Ботго буйлна.  
 Манайх олон төлтэй болов.



в. Асуултад хариулаарай. Хариултыг дэвтэртээ бичээрэй.

үхэр	}	яав?
адуу		
тэмээ		
хонь		
ямаа		

юу?	}	төрсөн бэ?
юу?		
юу?		
юу?		
юу?		



## ДАСГАЛ 3

а. Шүлгийг уран тод уншаад, цээжлээрэй.

### Жороо үг

Тугал тугал тоглоно  
 Туул голдоо очно  
 Унага унага тоглоно  
 Онон голдоо очно  
 Ботго ботго тоглоно  
 Богд ууландаа очно  
 Хурга хурга тоглоно  
 Хадан дээгүүр наадна  
 Ишиг ишиг тоглоно  
 Эргэн дээгүүр наадна.



гол



хад



эрэг

б. Асуултын дагуу ярилцаарай.



- Төл малыг нэрлэнэ үү?
- Тугал хаана тоглосон бэ?
- Унага хаана тоглосон бэ?
- Ботго хаана тоглосон бэ?
- Ишиг хаана тоглосон бэ?
- Хурга хаана тоглосон бэ?



Газрын нэрийг том үсгээр бичнэ.

*Онон гол, Туул гол, Ховд гол*

в. Өгүүлбэрийг дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.



Хурга, ишиг, унага, тугал, ботгыг төл мал гэнэ. Хавар мал төллөнө. Бид аав, ээждээ тусалдаг. Төл мал өхөөрдөм хөөрхөн. Төлөөр мал өснө.

гоё - хөөрхөн - өхөөрдөм - тоглоно - наадна

г. Юу? гэсэн асуултад хариулагдах үгсийг түүж бичээрэй.



## а. Уншаарай.



нохой	муур	шувуу	баавгай	үнэг	чоно
арслан	бар	заан	загас	могой	амьтан

## б. Зурагт эхийг уншаарай.

### Амьтны хүрээлэн



Чи амьтны хүрээлэнд очиж үзсэн үү?  
Тэнд олон амьтан байдаг.




Би энэ амьтдыг хэзээ ч харж байгаагүй. Бас олон шувууг харж болно. Амьтны хүрээлэнд очиж үзээрэй. Гайхалтай шүү.

## в. Асуултын дагуу ярилцаарай.




- Тэр хаана очсон бэ?
- Амьтны хүрээлэнд ямар, ямар амьтад байсан бэ?
- Чи амьтны хүрээлэнд очиж үзсэн үү?
- Чи ямар амьтанд дуртай вэ?

## г. Дэвтэртээ цэвэр сайхан бичээд, амьтдын нэрийн доогуур зураарай.



Туулай лууванд дуртай.  
Бөжин нь бас дуртай.



Баавгай баланд дуртай.  
Бамбарууш нь бүр ч дуртай.



## ДАСГАЛ 5

а. Зурагт эхийг уншаарай.



гөлөг  
гавар

муужгай  
бамбар

бөжин  
жараахай

бамбарууш  
үр төл

бэлтрэг  
зулзага

### Амьтны үр төл



-н зулзагыг гөлөг гэнэ.



-ын зулзагыг бэлтрэг гэнэ.



-ын зулзагыг муужгай гэнэ.



-ний зулзагыг гавар гэнэ.



-н зулзагыг бөжин гэнэ.



-ын зулзагыг бамбар гэнэ.



-н зулзагыг бамбарууш гэнэ.



-ний зулзагыг хувдай гэнэ.



-ы зулзагыг тугал гэнэ.



-ны зулзагыг дэгдээхэй гэнэ.

б. Асуултын дагуу ярилцаарай.



- Дээрх эхэд ямар амьтдын тухай өгүүлсэн бэ?
- Зулзага гэж юу вэ?
- Амьтдын үр төлийг юу, юу гэж нэрлэдэг вэ?
- Чи ямар амьтанд дуртай вэ?
- Чи амьтан тэжээдэг үү?

в. Үгсийг зөв байрлуулж, 3 өгүүлбэр зохиогоорой.





А. Зурагт эхийг уншаарай.

Хүү гөлөг хоёр



Б. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүү яагаад гөлгөө шийтгэсэн бэ?
- Хүү яагаад уйлсан бэ?
- Хүү гэрээ хэрхэн олсон бэ?



## ДАСГАЛ 7

а. Эхийг уншаарай.



### Тэмээ


Манай өвөөгийн гэр хөдөө байдаг. Тэднийх олон тэмээтэй. Дорж ах тэмээчин. Тэмээ таван хошуу малын нэг. Тэмээний төлийг ботго гэнэ. Тэр том биетэй. Тэмээний сүү амттай.

б. Асуултын дагуу ярилцаарай.



- Хэдэн тэмээ байна вэ?
- Тэмээ ямар биетэй вэ?
- Тэмээний төлийг юу гэдэг вэ?
- Тэмээ малладаг хүнийг хэн гэдэг вэ?

в. Зургийн дагуу ярилцаарай.




г. Амьтдын үр төлийн нэрийг бүтээж, дэвтэртээ бичээрэй.



-н



-ын



-ний



н

-Ба

бам-

га

бө

-вар

-рэг

-рууш

бэлт


-жин

# IX БҮЛЭГ. БАЙГАЛЬ ДЭЛХИЙ


## ЗУРАГТ ТОЛЬ



4 улирал



өвөл




хавар



зун




намар




сар




од




сансар



дэлхий




тэнгэр



гараг эрхэс




үүл




цас




мөс



бороо



аянга



солонго




салхи



шуурга



нуур




гол




горхи




чулуу



халуун




хүйтэн




агаар



өвс



навч



ой мод




цаг агаар



мод тарих



урсах



ургах



хөлдөх



хайлах



## ДАСГАЛ 1

а. Холбоо үгсийг уншаарай.










бараан үүл  
халуун нар

ширүүн бороо  
бороо орох

өнгийн солонго  
солонго татах

б. Зурагт эхийг уншаарай.

### Нар



Бараан  гарлаа. Ширүүн  оров. Өнгийн  татлаа.  
 орсны дараа  гарлаа. Халуун  болов.  гадаа  
 тоглов.

в. Асуултын дагуу ярилцаарай.



- Ямар үүл гарсан бэ?
- Юу орсон бэ?
- Юу татсан бэ?
- Хүүхдүүд хаана тоглосон бэ?
- Хэзээ нар гарсан бэ?

г. Оньсогыг таагаарай.



д. Асуултад тохирох үгийг олоорой. Өгүүлбэрийг дэвтэртээ бичээрэй.



Юу? гарлаа. Юу? оров. Юу? татлаа. Хэн? тоглов.



## а. Үгсийг уншаарай.



сар, өдөр  
цастай

цаг агаар  
салхитай

сэрүүн  
цэлмэг

дулаан  
халуун

бороотой  
хүйтэн

## б. Харилцан яриаг уншаарай.

### Цаг агаар

Өнөөдөр хэдэн сарын  
хэдэн бэ?

Ямар гараг вэ?

Өнөөдөр цаг агаар  
ямар байна вэ?



Өнөөдөр гуравдугаар  
сарын тавны өдөр.

Өнөөдөр Даваа гараг.

Өнөөдөр цаг агаар дулаан.  
Тэнгэр цэлмэг байна.

## в. Цаг агаарын мэдээг ажиглаад, ярилцаарай.

Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
Шөнө -1°C Багаатар үүлтэй 5м/с	Шөнө 4°C Үүшлэнэ 8м/с	Шөнө -3°C Хур тунадас 11м/с	Шөнө 3°C Багаатар үүлтэй 6м/с	Шөнө -3°C Хур тунадас 11м/с
Өдөр 14°C Багаатар үүлтэй 6м/с	Өдөр 13°C Бага зэргийн хур тунадас 13м/с	Өдөр 2°C Ялимгүй хур тунадас 9м/с	Өдөр 17°C Багаатар үүлтэй 8м/с	Өдөр 2°C Ялимгүй хур тунадас 9м/с

## г. Өгүүлбэр зохиож бичээрэй.

1.	2.	3.
4.	5.	6.
7.	8.	9.



**Заавар:**



1. Аянга цахилгаантай  
аадар бороо орж байна.



## ДАСГАЛ 3

### а. Уншаарай.



өвөл	хавар	зун	намар	улирал	ээлжлэх
өвс	навч	хөлдөх	хайлах	ургах	буцах

### б. Эхийг уншаарай.



### Дөрвөн улирал

Нэг жил дөрвөн улиралтай. Дөрвөн улирал ээлжилдэг. Өвлийн дараа хавар болдог. Хаврын дараа зун болдог. Зуны дараа намар болдог. Намрын дараа өвөл болдог. Улирал бүр гурван сартай.

### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Нэг жилд хэдэн улирал байдаг вэ?
- Нэг улиралд хэдэн сар байдаг вэ?
- Өвлийн дараа ямар улирал болдог вэ?
- Зун ямар улирлын дараа болох вэ?
- Намрын саруудыг нэрлээрэй.

### г. Хэсэг бүрт гарчиг өгч, дэвтэртээ бичээрэй.

Намар сэрүүн болдог. Өвс, навч шарлана. Шувууд буцдаг.

Өвөл хүйтэн болдог. Цас их ордог. Голын ус хөлдөнө.

Хавар цас мөс хайлна. Цаг агаар дулаарна. Өвс, ногоо ургана. Хавар мал төллөдөг.

Зун халуун болдог. Цэцэг дэлгэрнэ. Хүүхдүүд амарна. Хүмүүс хөдөө гарна.



а. Эхийг уншаарай.

Цастай хамт ирсэн найз

1



Цас оржээ. Хүү цасаар тоглов.

2



Хүү цас өнхрүүлээ.

3



Цас өнхөрсөөр улам бүр томорч байв.

4



Тэр цасаар том бөмбөг хийлээ.

5



Дахин нэг цасан Бөмбөг хийлээ.

6



Тэгээд гэрээсээ лууван авчрав.

7



Бас нэг модны мөчир олж ирэв.

8



Ороолт, малгайгаа ч өмсгөв.

9



Хүү өөрийн найзыгаа бүтээжээ.

б. Асуултын дагуу ярилцаарай.




- Хүү цаасаар юу хийсэн бэ?
- Хүүгийн бүтээсэн найз нь хэн бэ?
- Тэр найзыгаа юу, юугаар бүтээсэн бэ?

в. Асуултад тохирох үгийг олж өгүүлбэрийг дэвтэртээ бичээрэй.

Хэзээ ?

- цас мөс хайлна.
- голын ус хөлдөнө.
- цэцэг дэлгэрнэ.
- өвс, навч шарлана.





## ДАСГАЛ 5

а. Үгсийг уншаарай.



сар

од

тэнгэр

агаар

сансар

гараг

дэлхий

ангараг

дээшээ

доошоо

б. Дууны үгийг тод чанга уншаарай. Дуулж сураарай.

### Дээшээ дээшээ



Нар мэлтийнэ ээ  
 Саран дүнхийнэ ээ  
 Сансарт бид нар ниснэ ээ хө  
 Тэнгэр тойрно  
 Дэлхийг харна  
 Саранд бид нар очно оо хө



Эв нэгдлийн эвийн эгнээ дээшээ

Дээшээ, бүр дээшээ

Одод гялалзана аа

Гараг ярайна

Агаарт бид нар дүүлнэ ээ хө

Хүмүүс гайхна

Хүүхэд инээнэ ээ

Ангарагт бид нар очно оо хө

Эв хамтын эвийн эгнээ дээшээ

Дээшээ, бүр дээшээ



М.Чимэд

в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүүхдүүд хаана очсон бэ?
- Сансарт юу юу харагдаж байв?
- Хүмүүс яагаад гайхсан бэ?
- Манай гаргийн нэр юу вэ?



г. Шүлгээс гараг эрхсийн нэрийг олж бичээрэй.



а. Уншаарай.



ой мод	ашиг тус	тарих	хамгаалах	хүрз
шороо	хувин	бээлий	шороо	чулуу

б. Эхийг уншаарай.

**Ой модны ашиг тус**



Ой модтой газар цэвэр агаартай. Модтой газар ус байдаг.



Ойд олон амьтан амьдардаг.



Цаас, харандаа, дэвтэр, ном, хаалга, ширээ сандлыг модоор хийдэг.

Иймээс мод тарьж, ой модыг хамгаалъя.




в. Асуултын дагуу ярилцаарай.




- Модтой газар юу юу байдаг вэ?
- Модоор юу юу хийдэг вэ?
- Ой модыг хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

г. Мод тарихад юу хэрэгтэй вэ? Тоочин бичээрэй.



д. Мод тарих тухай ярилцаарай.





## ДАСГАЛ 7

а. Уншаарай.



аялах  
аянга

байгалийн үзэгдэл  
горхи

зугаалах  
цас

гараг эрхэс  
солонго

б. Зургийг ажиглаад харьцуулан ярилцаарай.



Ямар учраас дэлхий инээж байгаа бол?



Яагаад дэлхий уйлж байгаа бол?

в. Хүснэгтийг дэвтэртээ зураад, үгсийг бүлэглэж бичээрэй.



Ус гол, ...	Ой мод ой, ...	Байгалийн үзэгдэл аянга, ...	Гараг эрхэс од, ...
----------------	-------------------	---------------------------------	------------------------

г. Үгсийг зөв байрлуулан өгүүлбэр зохион бичээрэй.

хэн? бид би ах эгч	хэзээ? өвөл хавар зун намар	хаана? мөсөн дээр ойд хашаанд ууланд	юу хийсэн бэ? тоглосон зугаалсан гарсан мод тарьсан
--------------------------------	---	--	---



**Заавар:** Би өвөл мөсөн дээр тоглосон.

# Х БҮЛЭГ. ХУВЦАС

## ЗУРАГТ ТОЛЬ



малгай



ороолт



дээл



хүрэм



цамц



ноосон цамц



дүрэмт хувцас



даашинз



бээлий



пүүз



ботинк



гутал



оймс



эрээн ороолт



хос гутал



өрөөсөн гутал



зангиа



өмд



дотуур хувцас



унтлагын хувцас



хувцасны дэлгүүр



шинэ



хуучин



нимгэн



зузаан



зангиа зүүх



өмсөх



хувцсаа угаах



хувцсаа эвхэх



гутлаа тайлах



# ДАСГАЛ 1

## а. Уншаарай.



хувцас	цамц	даашинз	өмд	гутал	дээл
пүүз	оймс	өмсөх	тайлах	эвхэх	зүүх

## б. Уншаарай.

Энэ миний найз Гэрэл.  
Гэрэл ягаан даашинз,  
улаан гутал өмссөн  
байна.



Билгүүн ногоон  
цамц, бор өмд,  
цэнхэр ботинк  
өмссөн байна.

## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Охин ямар хувцас өмссөн бэ?
- Хүү ямар хувцас өмссөн бэ?
- Хэн ногоон цамц, цэнхэр гутал өмссөн бэ?

## г. Холбож уншаарай.

Улаан

- зүүв.
- аа өмсөв.

Хөх

- өө угаав.
- аа эвхэв.

## д. Өгүүлбэрийг уншаарай. Дэвтэртээ алдаагүй бичээрэй.

Эгч -аа угаав. Өвөө улаан өмсөнө. Эмээ тайлав. Аав хөх зүүнэ. Дүү хар авлаа. Билгүүн эвхэв.

цамцаа

дээлээ

гутлаа

зангиа

бээлий

өмдөө



а. Уншаарай.



үнэ  
уулзах

мянга  
таарах

төгрөг  
хувцасны дэлгүүр

худалдагч  
худалдаж авах

б. Харилцан яриаг уншаарай.

Хувцасны дэлгүүрт



Сайн байна уу?

Цэнхэр цамц ямар үнэтэй вэ?

Худалдагч аа, энэ цамц  
надад таарах уу?

Тэгвэл, энэ цамцыг авъя.

Баяртай.



Сайн, Сайн байна уу?

Цэнхэр цамц 8000 төгрөг.

Тийм ээ, чамд яг таарах байх.  
Өмсөж үзээрэй.

Баярлалаа. Баяртай.

в. Асуултын дагуу ярилцаарай.



Баяр хаана очсон бэ?

Хэнтэй уулзсан бэ?

Юу худалдаж авсан бэ?

Цамц ямар үнэтэй вэ?

г. Харилцан яриа зохиож, дэвтэртээ бичээрэй.



авъя

худалдагч

үзье

төгрөг

өмсье

үнэтэй вэ?



## ДАСГАЛ 3

### а. Уншаарай.



хос  
тавих

өрөөсөн  
одоо

өшиглөх  
нөгөө

урах  
лааз

зугтах  
чулуу

### б. Эхийг уншаарай.

#### Зугтсан гутал


Хүүхдүүд өдрийн хоолны дараа унтаж байлаа. Тэд гутал хувцсаа байр байранд нь тавьжээ. Гэтэл нэг гутал уйлж байв.

- Хүүе, яагаад уйлав аа?
- Энэ Ба... Ба... Бат намайг урчихсан... Би дэлгүүрт байхдаа ямар гоё байлаа. Гэтэл лааз, чулуу өшиглөөд ам хамрыг минь урчихсан... Одоо би яана аа. Ий... Ий... Ий...
- Нөгөө өрөөсөн чинь хаачсан бэ?
- Тэр, тэр зугтаж яваа.



*Л.Соронзонболд*

### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүүхдүүд юу хийж байсан бэ?
- Хэний гутал уйлсан бэ?
- Гутал яагаад уйлав?
- Гутлын өрөөсөн нь яасан бэ?
- Бат ямар хүүхэд вэ? Яагаад вэ?

### г. Холбоо үг зохиож дэвтэртээ бичээрэй.

өрөөсөн

хос





а. Уншаарай.



эрээн	алаг	ааш	зан
найрсаг зан	нандин хайр	зурчихлаа	будчихлаа



б. Шүлгийг тод чанга уншаарай. Цээжлээрэй.

**Миний ээж**

Ээж минь  
 Эрээн алчууртай  
 Ногоон дээлтэй  
 Ээжийгээ  
 Эрээн алчууртай нь  
 Ногоон дээлтэй нь  
 Зурчихлаа би  
 Будчихлаа би  
 Ээж минь  
 Найрсаг зантай  
 Наддаа хайртай  
 Нандин хайрыг  
 Хэрхэн зурах вэ?  
 Хэлж өгнө үү, та

*Ж.Дашдондог*



 зур-чих-лаа  
 буд-чих-лаа

в. Асуултын дагуу ярилцаарай.



Ээж ямар хувцас өмссөн бэ?

Ээж ямар зантай хүн бэ?

г. Дэвтэртээ бичээд, хос эгшигтэй үгсийн доогуур зураарай.

Найрсаг хөөрхөн ааштай байвал.  
 Найзууд олонтой байдаг юм.





## ДАСГАЛ 5

### а. Уншаарай.



гадаа  
шинэ

дотор  
хуучин

өвдөх  
зузаан

барих  
нимгэн

### б. Эхийг уншаарай.



#### Чих

Гадаа хүйтэн байлаа. Энхээг гарах гэхэд эмээ нь:  
 -Миний хүү малгайгаа өмсөөрэй гэв. Энхээ эмээгийнхээ  
 үгийг огт сонссон шинжгүй гарахад шинэхэн цас орсон  
 байлаа. Тэр цасан дээр дүрс зурж эхлэв. Тэгтэл гэнэт чих нь  
 өвдөв. Энхээ:  
 - Би одоо эмээгийнхээ үгэнд орно гэж чихээ барин уйлав. Гэвч  
 оройтсон байлаа.

### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Ямар улирал болж байсан бэ?
- Энхээд эмээ нь юу гэж хэлсэн бэ?
- Энхээгийн чих яагаад өвдсөн бэ?
- Энхээ эмээгийн үгэнд орсон бол яах байсан бэ?
- Өвөл ямар хувцас өмсдөг вэ?

### г. Үгсийг бүлэглэж бичээрэй.

Өнгө:  
Хувцас:



# ХИ БҮЛЭГ. ЁС ЗАНШИЛ, БАЯР ЁСЛОЛ

## ЗУРАГТ ТОЛЬ



намаржих



өвөлжих



зусах



хаваржих



цагаан сар



наадам



шинэ жил



наурыз



хүүхдийн баяр



гацуур



бялуу



бэлэг




өвлийн өвгөн



цасан охин



баяр хүргэх



зурвас



бөхийн барилдаан



морины уралдаан



сур харваа



төрсөн өдөр



хүчтэй



мэхтэй



хурдан



мэргэн



## ДАСГАЛ 1

### а. Уншаарай.



төрсөн өдөр  
мэндчилгээ

баяр хөөр  
баярын мэнд хүргэе

бэлэг  
аз жаргал хүсье

### б. Эхийг уншаад асуултад хариулаарай.

#### Төрсөн өдөр

Баатар долоон нас хүрэв. Найзууд нь ирэв.

- Найздаа төрсөн өдрийн мэнд хүргэе!
- Баярлалаа.

Найзууд нь “баяр хүргэе, үг хэлье, бэлгээ өгье” гэж баяр хөөр болцгоов.

Аз жаргал хүсье! гэцгээв.



### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Баатар хэдэн нас хүрсэн бэ?
- Төрсөн өдрийн баярт хэн ирсэн бэ?
- Баатар ямар бэлэг авсан бол?
- Та нар найзынхаа төрсөн өдөрт ямар бэлэг сонгох вэ? Яагаад? Нэрлээрэй.

### г. Загварын дагуу найздаа төрсөн өдрийн мэндчилгээ бичээрэй.



#### Мэндчилгээ

*Хайрт ээждээ төрсөн өдрийн баярын мэнд хүргэж,  
аз жаргал, сайн сайхныг хүсье! Тандаа хайртай шүү.*

*Охин Хулан, 2021-3-26*





### а. Уншаарай.



шинэ жил  
сүлд мод

өвлийн өвөө  
зурвас

цасан охин  
тэсэн ядан хүлээх

### б. Эхийг уншаад асуултад хариулж бичээрэй.

#### Өвлийн өвөөд бичсэн зурвас

Сайн байна уу? Өвлийн өвөө өө.

Би таны ирэхийг тэсэн ядан хүлээж байна. Та миний бэлгийг энэ хаягаар хүргэж өгөөрэй.

Манайх Өлгий сумын 4 дүгээр баг, Тэнгис 1 байрны 5 тоотод амьдардаг. Төв талбайн хойно музейн хажууд байгаа шүү.

Д.Бат 2022.12.31



### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Шинэ жил хэзээ болдог вэ?
- Бат хэнд захидал бичсэн бэ?
- Батын гэрийн хаяг юу вэ?

### г. Шинэ жилийн баяртай холбоотой асуултын зөв хариуг олоорой.

Хэн ирдэг вэ?	Найзууд ирдэг.	Өвлийн өвгөн ирдэг.
Юу өгдөг вэ?	Бэлэг өгдөг.	Даалгавар өгдөг.
Хэзээ болдог вэ?	6 сарын 1.	12 сарын 31.
Юу хийдэг вэ?	Сүлд модоо засдаг.	Бөмбөг тоглодог.
Хаанаас ирдэг вэ?	Улаанбаатараас ирдэг.	Цас мөсний орноос ирдэг.

### д. "Шинэ жил" сэдэвтэй эх зохион бичээрэй.



## ДАСГАЛ 3

### а. Уншаарай.



наадам

харваачид

бөх барилдах

хүчтэй

морь уралдах

мэхтэй

сур харвах

хурдан

### б. Эхийг уншаарай.



#### Наадам

Зуны улиралд наадам болдог. Наадмаар бөх барилдана. Бөх хүн хүчтэй, олон мэхтэй байдаг. Хурдан морь уралдана. Хүүхэд бүр хурдан морь унахыг хүсдэг. Мэргэн харваачид сур харвана.

### в. Асуултын дагуу ярилцаарай.



- Наадам хэзээ болдог вэ?
- Хүмүүс наадмаар юу хийдэг вэ?
- Бөх хүн ямар байдаг вэ?
- Чи хурдан морь унаж үзсэн үү?
- Хэн сур харвадаг вэ?
- Чи наадам үзэж байсан уу?

### г. Баяр, наадмууд хэзээ болдог вэ? Дэвтэртээ бичээрэй.



#### Заавар:

Хүүхдийн баяр 6 сарын 1-нд болдог.



## а. Уншаарай.



Сайхан хаваржиж байна уу?  
Сайхан өвөлжиж байна уу?

Сайхан намаржиж байна уу?  
Сайхан зусаж байна уу?

## б. Харилцан яриаг уншаарай.

Өглөөний мэнд хүргэе!



Өдрийн мэнд хүргэе!



Оройн мэнд хүргэе!



Амар мэнд байна уу?

Та сайхан хаваржиж байна уу?



Мэнд ээ.

Сайхан хаваржиж байна.

## в. Асуултын дагуу ярилцаарай.



- Мэндийн үг яагаад өөр өөр байдаг вэ?
- Өвөө, хүү хоёр юу гэж мэндэлдэг вэ?
- "Сайхан намаржиж байна уу?" гэж хэзээ мэндлэх вэ?
- "Сайхан зусаж байна уу?" гэж асуухад юу гэж хариулах вэ?

## г. Асуултад хариулж дэвтэртээ бичээрэй.



- Сайхан хаваржиж байна уу?      - Сайхан намаржиж байна уу?
- Сайхан өвөлжиж байна уу?      - Сайхан зусаж байна уу?



## ДАСГАЛ 5

а. Уншаарай.



хүндлэх

бусдын хайр

мэндлэх

хайр татах

түрүүлж

хүлэг

инээмсэглэж

сургаал

б. Эхийг уншаад асуултад хариулж бичээрэй.

### Мэндлэх ёс

Хүндлэх мэндлэхээс эхэлнэ. Хүнтэй түрүүлж мэндлэх хэрэгтэй. Хүнтэй инээмсэглэн мэндлээрэй. Зөв сайхан мэндэлдэг хүүхэд бусдын хайрыг татдаг.

в. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүндлэх юунаас эхлэх вэ?
- Яаж зөв сайхан мэндлэх вэ?
- Ямар хүүхэд хүмүүсийн хайрыг татдаг вэ? Яагаад вэ?

г. Зүйр цэцэн үгийг цээжлээрэй. Утгыг ярилцаарай.

Ах нь сургадаг  
Дүү нь сонсдог.

Хүн болох багаасаа  
Хүлэг болох унаганаасаа

Аавын сургаал алт  
Ээжийн сургаал эрдэм

д. Зурагт тохирох мэндийн үг бичээрэй.





а. Уншаарай.



хараал үг	ерөөл үг	цээжлэх	цээрлэх
ажил	амжилт	захиж сургана	сахиж үлгэрлэнэ

б. Шүлгийг уран уншаарай. Цээжлээрэй.

## Өвөөгийн сургаал

Хараал үгийг цээрлэж яв  
 Ерөөл үгийг цээжилж яв  
 Хүн бүрийг хүндэлж бай  
 Хэн бүхэнтэй мэндэлж бай



Ажил үйлд амжилт хүссэн  
 Аятай ерөөл айлтгаж сур  
 Өвөө надад захиж сургана  
 Өөрөө түүнийгээ сахиж үлгэрлэнэ.

Д.Санжжав

в. Асуултын дагуу ярилцаарай.



Өвөө ямар үгийг цээрлэж яв гэж сургасан бэ?



Ерөөлийн үг гэж юу вэ?

г. Үгсийг зөв байрлуулж, шүлгийг дэвтэртээ бичээрэй.

үгийг

Хараал

цээрлэж яв

цээжилж яв

үгийг

Ерөөл

бүрийг

Хүн

хүндэлж бай

Хэн

мэндэлж бай

бүхэнтэй

д. Ямар үед дараах үгийг хэлэх вэ? Тайлбарлаж яриарай.



Уучлаарай.



Баярлалаа



## ДАСГАЛ 7

### а. Уншаарай.



танилцах  
хамгийн гоё

айлын хүүхдүүд  
алаг толботой

гуйх  
гол руу

хайх  
гэр рүү

### Чулуутай танилцсан минь



- Ээж ээ, надад тоглоом өгөөч! гэж би нэг өдөр гуйлаа. Ээж:

- Гол дээр оч! Тэнд чиний тоглоом бий гэв. Би гол руу явлаа. Намайг гол дээр очиход айлын хүүхдүүд тоглож байв.

- Та нар юу хийж байгаа

юм бэ? гэж асуув.

- Тоглоом хайж байна гэж тэд хариуллаа.

- Ямар тоглоом? гэж асуувал

- Ийм тоглоом гэж нэг жаал жижигхэн дөрвөлжин чулуу үзүүлэв.

Тэр чулуу ногоон алаг дөрвөлжин толботой байв.

- Энэ бол авдар шүү. Одоо манайх хамгийн гоё авдартай айл болно гэж тэр чулууг олсон хүү хэлэв.

- Голын чулуун дотор байхгүй юм үгүй. Авдар сав, аяга, дээл, боов, чихэр, морь, тэмээ бүгд бий гэж нэг охин ярилаа.




Л.Түдэв

### б. Асуултын дагуу ярилцаарай.



- Хүү ээжээсээ юу гуйсан бэ?
- Ээж нь юу гэж хэлэв?
- Гол дээр очиход хүүхдүүд юу хийж байсан бэ?
- Чулуугаар ямар ямар тоглоом хийсэн бэ?
- Чи чулуугаар тоглож үзсэн үү? Хэзээ?
- Чи өөр ямар тоглоомоор тоглодог вэ?

### в. Өгүүлбэрийг уншиж, дэвтэртээ бичээрэй.



# БАТАТГАЛ

## ДАСГАЛ 1



### а. Уншаарай.



### Монгол хэлний хичээл

Бид хоёрдугаар ангид сурдаг. Манай ангид монгол хэлний хичээл ордог. Багш хичээлийг сонирхолтой заадаг. Би монголоор сонсож, уншиж, бичиж, ярьж сурсан. Монгол хэл дээр олон дуу, шүлэг цээжилсэн. Бид монгол хэлний хичээлд дуртай.

### б. Асуултын дагуу ярилцаарай.



- Чиний нэр хэн бэ?
- Танай аав, ээжийг хэн гэдэг вэ?
- Чи хэддүгээр ангид сурдаг вэ?
- Танай багшийг хэн гэдэг вэ?
- Танай ангид хэдэн хүүхэд сурдаг вэ?
- Танай ангид ямар, ямар хичээл ордог вэ?
- Монгол хэлний хичээл дээр юу хийдэг вэ?
- Монгол хэлний хичээлээр юу сурсан бэ?
- Чи монгол хэлний хичээлд дуртай юу? Яагаад вэ?

### в. Эхээс асуултад хариулах үг тус бүр хоёрыг олж бичээрэй.

Хэн?	<input type="text"/>
Юу?	<input type="text"/>
Яасан?	<input type="text"/>

### г. Эхээс хичээлийн хэрэглэлийн нэрийг түүж бичээрэй.



Үүргэвчит шинэхэн цүнхэнд минь Үзтэл бүгд бүрэн бий  
Үзэг, харандаа, ном, дэвтэр Үзэж сонирхох бүх юм бий.

### д. Үлдсэн хичээлийн хэрэглэлийн нэрийг нэмж бичээрэй.



## ДАСГАЛ 2

а. Шүлгийг тод чанга уншаарай. Цээжлээрэй.

### Дөрвөн улирал



Хүүхэд бидний  
Баяр болдог  
Хөгжөөнт зуны  
Улирал сайхан



Сүлд модны  
Наадам болдог  
Сүртэй өвөл  
Бас гайхам



Амтат жимсээр  
Бэлэг барьдаг  
Алтан намар  
Ай даа гоёхон



Зун, намар, өвлийн дараа  
Зугаатай бүгдийг дуурайсан  
Содон чамин хавар маань  
Сайхан, гоёхон гайхам

*Б.Доржсүрэн*

б. Эхийг уншаад, зургийн дагуу ярилцаарай.

### Машин

Туяа бохир болсон машинаа угаахаар болов. Эхлээд машинаа хөөсрүүлэн угаалаа. Дараа нь хөөсөө цэвэрхэн усаар шүршив. Эцэст нь машин цэвэрхэн сайхан боллоо.



**ХҮҮХДҮҮД ЭЭ, САЙХАН АМРААРАЙ!**

# МОНГОЛ ХЭЛ II ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын  
сургуулийн 2 дугаар ангид судална.

Зохиогчийн баг

Ахлагч:

Б.Аяужан

Гишүүд:

Ж.Гэрэлмаа

А.Аххайын

А.Бауыржан

Редактор:

Д.Эрдэнэсан

Ы.Нарау

Зураач:

Н.Буян

Хэвлэлийн эх бэлтгэгч:

Ц.Сугар

Формат: 84x108/16

Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м<sup>2</sup>

Хэвлэлийн хуудас: 8х.х

Хэвлэлийн эхийг “Содпресс” ХХК-д бэлтгэж,  
“Содпресс” ХХК-д 2955 хувь хэвлэв.

ISBN 978-9919-9714-9-6



9 789919 971496

